



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 400

Улаанбаатар хот

“Газаркапитал ББСБ” ХХК-ийг “Газарпартнерс ББСБ” ХХК-тай
нэгтгэхийг зөвшөөрөх, “Газаркапитал ББСБ” ХХК-ийн
банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, Компанийн тухай хуулийн 18, 20 дугаар зүйл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 18.1, 18.5, Хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.5.1, 10.5.10 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Газаркапитал ББСБ” ХХК-ийг “Газарпартнерс ББСБ” ХХК-д нэгтгэхийг зөвшөөрсүгэй.
2. “Газаркапитал ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
3. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Газарпартнерс ББСБ” ХХК /С.Мөнхгэрэл/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000486